



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

“Батжиннэгдэх үрс ББСБ” ХХК-ийн зээлийн үйл<sup>1</sup>  
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 10.4.1, 10.4.3<sup>1</sup> дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Батжиннэгдэх үрс ББСБ” ХХК-ийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан холбогдох өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримтыг 2015 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Батжиннэгдэх үрс ББСБ” ХХК /Ч.Ариунжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

030713